



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Журам батлах тухай.

Тус дүүргийн Засаг дарга, Татварын хэлтсээс орон тооны бус ажилтан ажиллуулах журмын төсөл боловсруулан батлуулах хүсэлт ирүүлснийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд орон нутгийн төсвийн орлогыг жигд ханган биелүүлэхэд туслалцаа үзүүлэх, төсвийн орлогыг бүрдүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус ажилтныг дүүргийн Татварын хэлтэст ажиллуулах албан ажлын зайлшгүй шаардлага байгааг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтэст орон тооны бус ажилтан ажиллуулах журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Орон тооны бус ажилтны тоог 45 /дөчин тав/-аар тогтоон нэг жилийн хугацаагаанд ажиллуулж, тэдэнтэй хөлсөөр ажиллах гэрээг байгуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Эрх зүй төрийн байгуулалтын хороо /Б.Мягмарсүрэн/-нд даалгасугай.

ДАРГА



Б.МӨНХЦЭЦЭГ

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
2019 оны 01 дүгээр сарын 17-ны  
өдрийн 1/10 дугаар тогтоолын хавсралт



## ОРОН ТООНЫ БУС АЖИЛТАН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд туслалцаа үзүүлэх, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх, татвар төлөгчдийн бааз суурийг өргөжүүлэх зорилгоор орон тооны бус ажилтан ажиллуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

#### Хоёр. Орон тооны бус ажилтан ажиллуулах

2.1. Дүүргийн татварын хэлтэст ажиллах орон тооны бус ажилтныг батлагдсан төсөвт багтаан Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлийг баримтлан хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулан ажиллуулна.

2.2. Дүүргийн татварын хэлтэс нь нягтлан бодогч, санхүү эдийн засагч болон эрх зүйч мэргэжилтэй, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, ажлын дадлага туршлагатай, гэмт хэрэгт холбогдож байгаагүй иргэдээс орон тооны бус ажилтныг сонгон авч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

2.3. Орон тооны бус ажилтныг гэр хороолол, худалдаа, үйлчилгээний байгууллага, дэлгүүр, зах, авто тээврийн шалган бүртгэх товчоо зэрэг газарт ажиллуулна.

#### Гурав. Орон тооны бус ажилтны эрх, үүрэг

3.1. Ажлынхаа үр дүнгийн тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр гарган ажлаа дүгнүүлнэ.

3.2. Орон тооны бус ажилтан нь татвар төлөгчдийг хүндэтгэн ажиллана.

3.3. Төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, татварт хамрагдаагүй, нуугдмал орлогыг илрүүлэх, кодгүй өрхийн хог хаягдлын хураамж хураах, татвар төлөгчдийн бааз, татварын орлогыг нэмэгдүүлэхэд татварын улсын байцаагчийн үйл ажиллагаанд туслан ажиллана.

3.4. Орон тооны бус ажилтан нь Татварын ерөнхий хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөн хөлсөөр ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

3.5. Эрхэлсэн ажилдаа идэвх санаачлаг гаргаж мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаж, цагийн хуваарийг мөрдөж ажиллана.

3.6. Орон тооны бус ажилтан нь ажлын үнэмлэх, энгэрийн тэмдэг хэрэглэх бөгөөд загвар, хэрэглэх зааврыг дүүргийн Татварын хэлтсийн дарга батална.

Дөрөв. Орон тооны бус ажилтны хөлс

4.1. Дүүргийн татварын хэлтэст ажиллах орон тооны бус ажилтны хөлс, үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Орон тооны бус ажилтны хөлсийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтад заасан цалингийн доод жишгийн ТҮ-6.1 зэрэглэлээр дүйцүүлэн олгох бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлнө.

Тав. Хариуцлага

5.1. Татварын хууль болон холбогдох хууль тогтоомж, Хөлсөөр ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчсөн тохиолдолд орон тооны бус ажилтны хөлсөөр ажиллах гэрээг цуцална.